

## **ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ ХУДАЛДАН АВАХ**

### **САНАЛ АВАХ ХҮСЭЛТ (ACAX)**

Төслийн нэр: **Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл**

Санхүүжилтийн эх үүсвэр: **МОН3810 - Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл**

Гэрээний дугаар ба нэр: **Б23**

Хүсэлтийг гаргасан огноо: **2024 оны 6 дугаар сарын 21**

1. Бoomтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын алба (захиалагч) нь дараах нэрийн барааг нийлүүлэх үнийн саналыг ирүүлэхийг үүгээр хүсч байна:

#### **СҮХБААТАР АЙМГИЙН БИЧИГТ ХИЛИЙН БООМТЫН 2 ШИРХЭГ УСТ ЦЭГИЙН ХАЙГУУЛ, ХУДГИЙН ӨРӨМДЛӨГ, БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ**

Хэрэв та энэхүү худалдан авах ажиллагааны гэрээний зураг төсөл, техникийн тодорхойлолтыг бэлтгэсэн, эсхүл төслийг бэлтгэхэд оролцсон компани, эсвэл ажлыг хянах үүрэг гүйцэтгэх компанийтай хамтран оролцож байгаа бол таны саналаас татгалзана

Танд үнийн санал бэлтгэхэд туслах зорилгоор шаардлагатай үзүүлэлт, ажлын тоо хэмжээ, зураг, санал ирүүлэх маягт, болон гэрээний маягтыг хавсаргав. Санал бэлтгэхийн тулд та өөрийн зардлаар ажлын талбайтай танилцаж, холбогдох мэдээллийг авч болно.

2. Та үнийн саналын нэг эх хувийг саналын маягтын хамт ирүүлнэ.

3. Хавсралт маягтын дагуу бэлтгэсэн таны санал нь гарын үсэг зурагдаж, дугтуйнд хийж битүүмжлэгдэн, хаяглагдсан байх ёстой бөгөөд дараах хаягт хандан илгээнэ:

Захиалагчийн хаяг: **Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын алба  
Засгийн газрын 12-р байр, 4 давхар, 431 тоот  
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай, Улаанбаатар**  
Утас: **976-75553387**  
Цахим шуудан: **[procurement.ribs@gmail.com](mailto:procurement.ribs@gmail.com)** (зөвхөн тодуулга авах зорилгоор)

4. Та сүүлийн 3 жилд агуулга ба иж бурдлийн хувьд энэ санал авах хүсэлтэнд дурдсан ажилтай ижил төстэй, нэгээс доошгүй ажлыг хийсэн туршлагатай, мөн тухайн ажлыг гүйцэтгэж дуусгасан ажлын акт эсвэл захиалагчаас ирүүлсэн тодорхойлолттой байх ёстой. Шаардлага хангаагүй тохиолдолд, таны саналыг цаашид үнэлгээнд харгалзахгүй.

5. Та зөвхөн нэг саналыг ирүүлнэ. Та саналаа арилдаггүй бэхээр бичих ёстой бөгөөд та эсвэл таны эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулна. Таны саналын маягт гарын үсэггүй тохиолдолд, таны саналыг цаашид үнэлгээнд харгалзахгүй.

6. Захиалагч саналуудыг үнэлэхдээ, тооцооллын алдааг дараах байдлаар залруулна:

- (а) тоогоор болон үгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрүүтэй бол үгээр илэрхийлэгдсэннийг зөв гэж үзэх;
- (б) үнэлэгдсэн ажлын хүснэгт (эсхүл ажлын тоо хэмжээ)-д заасан нийт үнэ ба саналын маягтанд заасан үнийн хооронд зөрүүтэй бол үнэлэгдсэн ажлын хүснэгт (эсхүл ажлын тоо хэмжээ) дэх нийт үнийг баримтлах;
- (в) нэгж үнийг тоо хэмжээгээр үргүүлсэнтэй холбоотойгоор нэгж үнэ ба нийт үнийн хооронд зөрүүтэй бол нэгж үнийг баримтлах; ба
- (г) гүйцэтгэгч залруулгыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал, түүний санаалаас татгалзана.

7. Таны санал **2024 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш 60 өдрийн хугацаанд хүчинтэй байна.**

8. **Монгол хэл** дээр үйлдэгдсэн таны санал нь нийт ажлыг хамарсан байх ба үнэлэгдсэн ажлын хүснэгтэд үндэслэгдсэн байна. Санал болгосон үнэ ба төлбөрийг **төгрөгөөр** гүйцэтгэнэ. Саналд дотоодын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчид төлөх бүх гаалийн татвар, дотоодын татвар ба бусад хураамжийг тусгаж оруулна.

9. Захиалагч гэрээний эрхийг энэхүү санал авах хүсэлтийг үндсэнд нь хангаж байгаа санал, түүнчлэн хамгийн сайн үнэлэгдсэн үнийн санал ирүүлсэн гүйцэтгэгчид олгоно. Хэрэв тухайн санал нь том зөрүү агуулсан, эсвэл санал авах хүсэлтэд заасан нөхцөл, шаардлага, тодорхойлолтын хувьд болзолт нөхцлийг шаардсан бол ийм саналыг үндсэндээ шаардлагад нийцэхгүй гэж үзэх ба түүнийг цаашид үнэлгээнд харгалзахгүй. Захиалагч зөвхөн үндсэндээ шаардлагад нийцсэн саналуудыг үнэлж харьцуулна.

10. Хэрэв та тендерийн хүчинтэй хугацаанд өөрийн саналаа буцааж авах ба/эсвэл гэрээний эрх олгогдсон байхад гэрээний эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал таныг хоёр жилийн хугацаанд тухайн төслийн гүйцэтгэгчийн жагсаалтаас хасна.

11. Гэрээний маягтад хавсаргасан нөхцөл ба шаардлагын дагуу энэ гэрээг хэрэгжүүлнэ.

12. Та саналаа саналын маягт болон бөглөсөн 2 дугаар хэсэг болох “**үнэлэгдсэн ажлын хүснэгтийн хамт 2024 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 11.00 цагаас өмнө дугуйнд хийж битүүмжлэн ирүүлнэ**. Саналуудыг, оролцохоор шийдвэрлэсэн гүйцэтгэгчийн төлөөлөгчийг байлцуулан, **2024 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 11.00 цагт** дараах хаяг бүхий газарт нийтийн өмнө нээнэ.

**Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын алба  
Засгийн газрын 12-р байр, 4 давхар, 431 тоот  
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай, Улаанбаатар**

13. Захиалагч санал ирүүлэх хугацаанаас хойш **5 өдрийн дотор** санал нь хүлээн зөвшөөрөгдсөн тендерт оролцогчид зөвшөөрлийн захидалыг илгээж, гэрээний эрх олгосон тухай мэдэгдэнэ.

14. Захиалагч нь энэхүү санал авах хүсэлтийн үр дүнд гарсан худалдан авах

захиалгын хүрээнд хийгдэх эрх бүхий төлбөрт Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны сангийн эх үүсвэрийг хэрэглэнэ.

15. АХБ-ны авлигын эсрэг бодлогын дагуу, тендерт оролцогч худалдан авах ажиллагаа болон түүнээс үүдэн гарах гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг сахина. Хэрэв гэрээний эрх авсан тендерт оролцогч эсвэл аливаа бусад этгээд тендерт өрсөлдөх эсвэл гэрээг хэрэгжүүлэх үед авилгал, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах эсвэл дарамт шахалт үзүүлэх үйлдэлд оролцсон нь тогтоогдвол АХБ гэрээний эрх олгох санаалаас татгалзаж, үүнд холбогдсон талуудад хориг тогтооно. Саналаа ирүүлэх тэр мөчид, та АХБ-ны хориг жагсаалтанд ороогүй байвал зохино.

16. Та факсаар/цахим шуудангаар энэхүү хүсэлтийг авсан тухай болон үнийн санал ирүүлэх эсэхээ мэдэгдэнэ үү.

ХҮНДЭТГЭСЭН,



О.НАРАНДЭЛГЭР  
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ

# 1 ДҮГЭЭР ХЭСЭГ – ЕРӨНХИЙ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## СҮХБААТАР АЙМГИЙН БИЧИГТ ХИЛИЙН БООМТЫН 2 ШИРХЭГ УСТ ЦЭГИЙН ХАЙГУУЛ, ХУДГИЙН ӨРӨМДЛӨГ, БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

### ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1	Байршил, нэр, үйл ажиллагаа	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах “Бичигт” хилийн боомт
2	Шинээр гаргах худгийн гүн, ундарга	<ul style="list-style-type: none"><li>- Худгийн гүн-Хайгуулын дүгнэлт дээр үндэслэнэ.</li><li>- Усны ундарга 2-6 л/с</li></ul>
3	Одоогийн байдал	Тус боомтын шинээр төлөвлөж, барьж буй газар гүний худаг байхгүй. Шинээр хайгуулийн ажил хийж гүний худаг гаргах шаардлагатай. <ul style="list-style-type: none"><li>- Худгийн өрөмдлөгийн шаардлагатай гүн-200 метрээс дээш</li><li>- Усны чанар-эрдэсжилт ихтэй</li><li>- Усны ундарга тооцоо байхгүй</li></ul>
4	Тооцоо төсөв	Төсвийг БНБД 81-95-12 дагуу эрх бүхий байгууллагын зөвшөөрсөн программаар тооцно.
5	Галын аюулгүй байдлын нөхцөл	Галын аюулгүй байдлын холбогдох норм дүрэм, шаардлагыг хангасан байна.
6	Тайлангийн үе шат	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.
7	Зөвшөөрөлцөх байгууллага	Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын алба, Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл, Бичигт дахь Гаалийн Газар

## ЕРӨНХИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

<b>д/д</b>	<b>Техникийн тодорхойлолт</b>
<b>Нэг: Хайгуулын ажил</b>	
1	<ul style="list-style-type: none"> <li>- Шинэ худгийн цэг тогтоох хайгуулын ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, өрөмдлөгийн компани өөрсдөө энэ ажлыг гүйцэтгэх бол холбогдох зөвшөөрөлтэй байх бөгөөд ашиглагчтай хамтран худгийн байршлыг эцэслэн тогтоох</li> <li>- Гэрээний дагуу хүлээгдэж буй үр дүнд хүрэхэд шаардагдах хайгуулын ажилд шаардагдах аливаа зураг төслийн ажил, материал, хөдөлмөрийн тоног төхөөрөмжийн сонголт зэргийг гүйцэтгэх</li> </ul>
<b>Хоёр: Худгийн цооног өрөмдөх, барилгын ажил</b>	
2	<p>Гүний худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж сууринуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2010 стандартын дагуу худгийн цооногийн өрөмдлөг хийх, шавхалт, туршилтын ажлыг явуулах, гүний усны шахуурга, худгийн барилга барих зэрэг ажлыг иж бүрнээр нь хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гүний худгийн ажлын зураг төсвийг норм стандартын дагуу боловсруулах</li> <li>- Худгийн цооногийг өрөмдлөгийн ямар аргаар гүйцэтгэх тухай танилцуулга ирүүлэх /Аймаг, орон нутгийн онцлогоос хамаарах/</li> <li>- Өрөмдлөгийн ажлыг тогтоосон талбайд өөрийн эрсдэлийг тооцож, дурын цэгийг сонгох</li> <li>- Цооног өрөмдөх эхний /диаметр/, шүүр яндангийн, цооногийн эцсийн голчийн болон ус шахуургын голчийн хэмжээг тус тус заах. /Аймаг, орон нутгийн онцлогоос хамаарах/</li> </ul> <p>Өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж шавхалт үйлдэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орчин үеийн шинэлэг техник технологи, материал хийцлэлийг тусгасан гүний ус өргөх насос, ус шахах шахуурга, ус цэвэршүүлж зөвлүүлэх тоног төхөөрөмж угсралт</li> <li>- Гадна цэвэр усны шугам хоолой хийх ажил Ф-50мм, /Худгийн барилгаас усан сангийн барилга хүртэлх 30м зайд хийгдэхээр зардлаа тооцож ирүүлэх/</li> <li>- Бoomтын зорчигч болон ачаа тээврийн хэсгийг усаар тасалдалгүй хангаж байхаар тооцоо гаргах, судалгаа хийх</li> <li>- Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаарх мэдээлэлийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэх.</li> <li>- Худгийн барилга нь БНБД 81-06-06, БНБД 81-10-06, БНБД 81-11-06, БНБД 81-12-06, БНБД 81-16-06-д заасан үзүүлэлт, шаардлагыг хангасан байна. Худгийн барилгын өрөг нь өрөгт бүтээц БНБД 51-02-05, Дээврийн ажил нь дээврийн хучлага БНБД 31-02-03, Шал нь БНБД 31-12-08 зэрэг барилгын норм дүрмийг хангасан байна.</li> </ul>
<b>Гурав: Ус шахуурга</b>	
3	<p>Инженерийн хийцтэй худгийн ус шахуурга, шахуургын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооногт сууринуулахаар тусгана:</p> <p>Ус шахах шахуурга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байна.</li> </ul> <p>Гүний ус өргөх насос:</p>

д/д	<b>Техникийн тодорхойлолт</b>
	<ul style="list-style-type: none"> <li>- ISO 9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх</li> </ul> <p>Цахилгааны утас:</p> <ul style="list-style-type: none"> <li>- З салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн(залгаасгүй), ус өргөх яндан 2м тутамд хавчиж (туузаар ороож болохгүй) тогтоох.</li> </ul> <p>Хянах самбар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Асаах, унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортай, насос ажиллуулах асаагууртай байх.</li> </ul>
<b>Дөрөв: Цооногт шүүрийн яндан суурилуулах</b>	
4	<p>Цооногт суурилуулах шүүрийн яндангийн төрөл, хийц, загвар хэмжээ ашиглах материалд тавих шаардлагууд: /MNS 6088:2010-ын дагуу/</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шүүрийн янданг цайрдсан ган, зэвэрдэггүй ган, зохих журмын дагуу хийсэн хайрган шүүр, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолойгоор хийх</li> <li>- Шүүрийн янданг зэвэрдэггүй ган утсаар ороож бэлтгэх ба шүүрийн хэсгийг ороосон утас хоорондын зайд нь 1-2мм байх.</li> <li>- Шүүрийн янданг суултын яндантай залгаж хийхдээ цахилгаан гагнуур ашиглах ба залгааны 4 талд нэмэлт холбоос тавьж гагнах.</li> <li>- Цооногт шүүрийн янданг эгц босоо суулгаж ус шүүх нэмэлт хайргыг хийхдээ суултийн яндангийн дээд, доод хэсэгт чиглүүлэгч байрлуулах.</li> <li>- Цооног дах хэд хэдэн уст үеийг ашиглахаар тооцсон бол тус бурд нь шүүрийн яндан тавьж, шүүрийн янданг хооронд нь битүү яндангаар холбох.</li> <li>- Холбоос яндангууд нь уст үеийг хаахгүй байхаар суулгасан байна. Уст үеүд ундарга багатай бол цооногийг том голчоор өрөмдөж 100мм зузаан хайрган шүүр тавьж ашиглах.</li> </ul>
<b>Тав: Худгийн ажил дуусгаж хүлээлгэж өгөх</b>	
5	<ul style="list-style-type: none"> <li>- Инженерийн хийцтэй гүний худаг шинээр гаргахдаа далд ажлын акт үйлдэж, ашиглагчид хүлээлгэн өгөх.</li> <li>- Талбайг цэвэрлэх/өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал зэргийг ачиж зайлцуулсан байх/</li> <li>- Худгийн гүний насос ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалт өгөх</li> <li>- Худгийн паспорт бэлтгэж аймгийн БОАЖГ-аар баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгөх.</li> <li>- Усны химийн болон бактериологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөх</li> </ul>

## 2 ДУГААР ХЭСЭГ – ҮНЭЛЭГДСЭН АЖЛЫН ХҮСНЭГТ

**Жич:** Үнийн санал ирүүлэгч нь Ажлын төрөл бүрт нийт үнийг зааж өгнө. Үнийн санал ирүүлэгч нь аг нэг нэр төрлийн ажлын нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд бусад нэр төрлийн ажлын ний үнэд багтсан гэж үзэх бөгөөд захиалагч ийм ажлын гүйцэтгэлийн төлбөрийг хийхгүй. Хуваар тусгагдсан арга хэмжээний үнийн дүнгийн нийлбэр нь тендерт оролцогчийн "нэг хариуцлаг зарчмаар ажлыг дуусгах тендер бөгөөд энэхүү гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлыг бүрэн хэмжээгээ хүргэхэд шаардагдах бүх зардлыг нөхөхөөр тооцсон болно. Хаалтанд заасан хэмжигдэхүүнүүд ө зөвхөн заалт юм.

No.	Ажлын нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нийт үнэ
<b>А. Гүйцэтгэгчийн бэлтгэл ажил</b>				
1	Ерөнхий зүйл	1	Нийт үнэ	
<b>Б. Хайгуулийн ажил</b>				
1	Худгийн хайгуулийн цэг тодорхойлох	1	Нийт үнэ	
<b>В.1 Газрын ажил</b>				
1.1	Барилга барих талбайг бульдозероор тэгшлэх - 32.4 m <sup>2</sup>	1	Нийт үнэ	
1.2	1м хүртэл гүн 2-р зэргийн хөрсөнд суурь гараар ухах - 7.69 m <sup>3</sup>	1	Нийт үнэ	
1.3	Суурийн хажуугаар овойлт үүсэхгүй хөрсөөр нягтруулж булах - 1.08 m <sup>3</sup>	1	Нийт үнэ	
1.4	Түүдэгээ 1мр 2-р шириин зөвхөж, шаглан дүүр 300мм хүртэл зузаантай дэвсгэр үе хийж нягтруулах - 1.35 m <sup>3</sup>	1	Нийт үнэ	
<b>В.2 Суурийн ажил</b>				
2.1	Бетон шахах шахуургаар бетон бэлтгэл хийх B7,5 - 1.13 m <sup>3</sup>	1	Нийт үнэ	
2.2	Бетон шугаман суурь цутгах B12.5 - 4.8 m <sup>3</sup>	1	Нийт үнэ	
2.3	120мм-ийн ханын суурь цутгах B12.5 - 1.56 m <sup>3</sup>	1	Нийт үнэ	
2.4	Бетон ба дэвсгэр үеийг арматурчилах - 0.14 tn	1	Нийт үнэ	
2.5	Суурийн гадаргууд ус тусгаарлагчийг битум түрхлэгээр 2 үе хийх - 26.29 m <sup>2</sup>	1	Нийт үнэ	
<b>В.3 Хучилт дээврийн ажил</b>				
3.1	Тоосгон ханатай барилгын бандан зулавчтай модон хучилт хийх - 11.56 m <sup>2</sup>	1	Нийт үнэ	
3.2	Дээврийн 1 үе наамал уур тусгаарлагч хийх - 11.56 m <sup>2</sup>	1	Нийт үнэ	
3.3	Таазан дээр 1 үе 15см зузаан чулуун хөвөн хавтан дулаалга хийх M120кг/m <sup>3</sup> - 11.56 m <sup>2</sup>	1	Нийт үнэ	
3.4	Дээврийн дулаалгын дээр 1 үе уур тусгаарлагч хийх - 11.56 m <sup>2</sup>	1	Нийт үнэ	
3.5	Бандан шувуу нуруу угсралт - 0.24 m <sup>3</sup>	1	Нийт үнэ	
3.6	4кг хүртэл жинтэй бэхэлгээний деталь төмөр суулгах - 0.012 tn	1	Нийт үнэ	
3.7	Модон сараалжтай долгионт төмөр дээвэр хийх e=0.8мм - 20.22 m <sup>2</sup>	1	Нийт үнэ	

<sup>1</sup> Хоёр худгийн нийт үнийг оруулна.

No.	Ажлын нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нийт үнэ
3.8	Тоосгон фронтод аваарийн хаалга хийх	1	Нийт үнэ	
3.9	0.1m2 хүртэл талбайтай салхивчийн тор суулгах, агууржуулалтын хоолойг дээврийн хонгилоор угсрах	1	Нийт үнэ	
3.10	Агааржуулалтын шүхрийг фронтоор гаргаж угсрах - 0.01 m2	1	Нийт үнэ	
3.11	Дээврийн хормойг битүүлж цэвэр банзан карниз угсрах - 7.16 m2	1	Нийт үнэ	
3.12	Дээврийн ус зайлзуулах эдлэл хоолойг барилгын хоёр талд угсрах - 18 m2	1	Нийт үнэ	

#### B.4 Хана хамар ханын ажил

4.1	Ердийн тоосгоор энгийн гоёлтой 200мм-ийн тоосгон хана цемент шохойн зуурмагаар гагнаж өрөх - 5.46 m3	1	Нийт үнэ	
4.2	Хана хөөсөнцөрөөр дулаалах б=100мм - 34.59 m2	1	Нийт үнэ	
4.3	1/2 өнгөлгөөний тоосгоор гадна хана өнгөлж өрөх - 37.55 m2	1	Нийт үнэ	
4.4	1/2-ын өргөн ердийн тоосгон хамар хана арматурлаж өрөх - 9.75 m2	1	Нийт үнэ	
4.5	0.1тн хүртэл жинтэй ялуу Я15.12.14	4	Нийт үнэ	
4.6	0.1тн хүртэл жинтэй ялуу Я12.12.8	1	Нийт үнэ	
4.7	2.5м хүртэл урт модон ялуу хийж угсрах	2	Нийт үнэ	
4.8	Бетон шахах шахуургаар хэв хашмалтай бүс төмөр бетоноор цутгах М-100 - 0.36 m3	1	Нийт үнэ	
4.9	Довжоог төмөр бетон гишгүүрийн хамт цутгах - 0.12 m3	1	Нийт үнэ	
4.10	Хаяавч цутгах М100 /13.6x1.0x0.1/ - 1.36 m3	1	Нийт үнэ	

#### B.5 Хаалга, цонхны ажил

5.1	Вакум цонх угсрах - 1.8 m2	1	Нийт үнэ	
5.2	Цонхны зайд завсарыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих дулаалах - 1.8 m2	1	Нийт үнэ	
5.3	Дотор талаасаа түгжигдэг төмөр цонхны хаалт хийж угсрах 1.5x1.2 - 1.8 m2	1	Нийт үнэ	
5.4	Цонхны чулуун тавиур хавтан суулгах - 0.54 m2	1	Нийт үнэ	
5.5	Змм зузаантай лист төмөртэй 80*80*6-ын угольниkin рамтай дулаалгатай хамгаалалтын төмөр хаалга угсрах - 2.0079 m2	1	Нийт үнэ	
5.6	Цахилгаан соронзон цоож төмөр хаалганд угсрах	1	Нийт үнэ	
5.7	Хаалганд хэрэглэл угсрах	1	Нийт үнэ	
5.8	Гадна дотор тоосгон хананд модон хаалга угсрах - 3.27 m2	1	Нийт үнэ	
5.9	Хаалга өнгийн тосон будгаар гар аргаар ердийн будах - 6.54 m2	1	Нийт үнэ	
5.10	Хаалганы зайд завсарыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих - 5.27 m2	1	Нийт үнэ	
5.11	Цонхны зайд завсарыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих дулаалах - 1.8 m2	1	Нийт үнэ	


#### B.6 Шалны ажил

No.	Ажлын нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нийт үнэ
6.1	Үнс ба керамзитаар дулаан ба дуу тусгаарлалт хийх б=30см /2.7*2.6*0.3/ - 2.1 m3	1	Нийт үнэ	
6.2	Ус тусгаарлалт хийх 1 ўе гялгар цаас - 7.02 m2	1	Нийт үнэ	
6.3	Бетон бэлтгэл б=15мм - 0.11 m3	1	Нийт үнэ	
6.4	Бетон шал цутгах б=20мм - 0.14 m3	1	Нийт үнэ	
6.5	20 мм зузаан бетон тэгшилгээ хийх - 7.02 m2	1	Нийт үнэ	
6.6	Хүйтэн түрхлэг дээр хулдаас нааж шал хийх - 7.02 m2	1	Нийт үнэ	
6.7	Шалны хөвөө мод бэлтгэж хадах - 0.106/100m	1	Нийт үнэ	
<b>В.7 Дотор заслын ажил</b>				
7.1	Дотор тоосго ба бетон ханыг шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах - 30.6 m2	1	Нийт үнэ	
7.2	Хананд замаска хийх - 30.6 m2	1	Нийт үнэ	
7.3	Шаардлагатай хана будгаар, гар аргаар будах - 30.6 m2	1	Нийт үнэ	
7.4	Цонхны амалгаа шавардах - 2.69 m2	1	Нийт үнэ	
7.5	Цонхны амалгааг цагаан өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах - 2.69 m2	1	Нийт үнэ	
7.6	Таазанд бруссээр рам зангидааж бэхлэх - 7.02 m2	1	Нийт үнэ	
7.7	Таазыг 5мм-ийн зузаан өнгөт хуулгатай эслэг хавтангаар тааз бүрэх - 7.02 m2	1	Нийт үнэ	
7.8	Таазанд хөвөө мод бэлтгэж хадах - 1.06/100m	1	Нийт үнэ	
7.9	Гадна хананд кабанчик хавтан наах - 4.08 m2	1	Нийт үнэ	
7.10	Довжоог төмөр бетон гишүүрийн хамт цутгах - 1.3 m3	1	Нийт үнэ	
7.11	20 мм зузаан бетон тэгшилгээ хийх - 1.44 m2	1	Нийт үнэ	
<b>В.8 Дотор гэрэлтүүлгийн ажил</b>				
8.1	Оролтын хувиарлах байгууламж угсрах /1 самбар/	1	Нийт үнэ	
8.2	Тоостой, чийгтэй байранд улайсах ламптай гэрэлтүүлэгч өлгөж угсрах	1	Нийт үнэ	
8.3	Ердийн нөхцөлийн байранд улайсах ламптай гэрэлтүүлэгч өлгөж угсрах	4	Нийт үнэ	
8.4	Далд угсрах унтраалга тавих	5	Нийт үнэ	
8.5	Хананд далд тоноглох газардуулагч контакттай хоёрлосон разетка угсрах	1	Нийт үнэ	
8.6	1x2.5мм2 хөндлөн огтлолтой зэс утас сүвлэх - 80 м		Нийт үнэ	
8.7	Розетка унтраалгын блок угсрах	5	Нийт үнэ	
8.8	Далд утас салбарлах хайрцаг угсрах	4	Нийт үнэ	
8.9	Хуванцар хоолойг хөдөлгөөнгүй бэхлэж хана, багананд иж бүрэн байдлаар угсрах д-25мм2 - 30 м	1	Нийт үнэ	
8.10	25*4 мм-ийн хөндлөн огтлолтой туузан төмрөөр хийсэн газардуулгын шинийг хувиарлах байгууламжийн бетон нүхэнд бэхлэх - 20 м	1	Нийт үнэ	
8.11	40*40мм-ийн хөндлөн огтлолтой туузан төмрөөр хийсэн газардуулалтын шинийг хуваарилах - 10 м байгууламжийн бетон нүхэнд бэхлэх	1	Нийт үнэ	

No.	Ажлын нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нийт үнэ
8.12	50*50*5мм хэмжээтэй булан төмөр газардуулагчыг гар ажиллагаагаар зоох	3	Нийт үнэ	
8.13	Цахилгаан хөдөлгүүрт газардуулалтын уян хатан холбоос гагнаж бэхлэх - 1 м	1	Нийт үнэ	
8.14	Цахилгаан халаагч угсрах Q950Вт 220V/50Hz	2	Нийт үнэ	
<b>Г. Тоног төхөөрөмж угсрах ажил</b>				
1.1	Ус цэвэршүүлж, зөөлрүүлэх тоног төхөөрөмж угсрах	1	Нийт үнэ	
1.2	Гүний ус өргөх насос угсрах: Худгийн гүнээс шалтгаалж тохирох насосыг сууринуулна	1	Нийт үнэ	
1.3	Ус шахах насос угсрах, Худгийн гүнээс шалтгаалж тохирох насосыг сууринуулна	1	Нийт үнэ	
1.4	Хянах самбар угсрах	1	Нийт үнэ	
<b>Д. Бусад</b>				
11.1	Гадна цэвэр усны шугам угсрах Ф-50мм /дулаалгатай, Худгийн барилгаас усан сангийн барилга хүртэлх 30м-ийн зайд/	1	Нийт үнэ	
<b>НИЙТ</b>				

## З ДУГААР ХЭСЭГ – ЗУРАГ ТӨСӨЛ

## Худгийн байрны зураг хавсаргав.



## САНАЛЫН МАЯГТ

\_\_\_\_\_ (Огноо)

Хэнд: \_\_\_\_\_ (Захиалагчийн нэр)

\_\_\_\_\_ (Захиалагчийн хаяг)

Бид \_\_\_\_\_ (гэрээний нэр ба дугаар)-г  
(гэрээний маягтанд заасан) гэрээний нөхцлийн дагуу \_\_\_\_\_  
(үнийн дүнг үсэг ба тоогоор илэрхийлэх) \_\_\_\_\_ (мөнгөн тэмдэгтийн нэр) бүхий  
гэрээний үнэтэй энэхүү саналын дагуу хэрэгжүүлэхээр санал болгож байна. Бид гэрээнд  
дурдсан ажлыг гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш \_\_\_\_\_ сарын дотор  
багтаан дуусгах саналтай байна.

Энэ санал болон таны бичгээр үйлдсэн зөвшөөрөл нь бидний хооронд байгуулах  
гэрээний хэсэг байх болно. Хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер болон бусад хүлээн  
авсан төндөрийг тэхүүлээн зөвшөөрөх үүрэг хүлээгээгүй гэдгийг бид ойлгож байна.

Энэ санал нь саналын баримт бичигт шаардсан саналын хүчинтэй хугацаатай нийцэж  
байгааг бид үүгээр баталгаажуулж байна.

Бид энэхүү санал авах хүсэлттэй уялдсан гэрээний зураг төсөл, тодорхойлолтыг  
бэлтгэсэн компанийтай хамтран оролцоогүй болно.

Бид АХБ-ны хориг жагсаалтанд ороогүй болно.

Эрх бүхий гарын үсэг: \_\_\_\_\_

Гарын үсэг зурах этгээдийн нэр ба албан тушаал: \_\_\_\_\_

Гүйцэтгэгчийн нэр: \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

Утасны дугаар: \_\_\_\_\_

Факсын дугаар, шаардлагатай бол: \_\_\_\_\_

Цахим шуудан хаяг (шаардлагатай бол): \_\_\_\_\_

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

Гэрээний нэр:

Бичигт хилийн боомтын Уст цэгийн хайгуул, худгийн  
өрөмдлөг, барилга угсралтын ажил

Гэрээний дугаар:

Б23

Энэ гэрээг 2024 оны \_\_\_\_ дүгээр сарын \_\_\_\_-ний өдөр нэг талаас Боомтын сэргэлтийн үндэсний хороо (цаашид “захиалагч” гэх) ба нөгөө талаас \_\_\_\_\_ (цаашид “гүйцэтгэгч” гэх) нар байгуулав.

Захиалагч гүйцэтгэгчээс \_\_\_\_\_ (гэрээний нэр ба дугаар) бүхий ажил гүйцэтгэх санал ирүүлэхийг хүссэний дагуу гүйцэтгэгч дээрх ажлыг хийх саналаа ирүүлсэн, бөгөөд энэ ажлыг хийж дуусгах, аливаа гэмтэл согогийг арилгах тухай 201\_ оны \_\_\_\_ дүгээр сарын \_\_\_\_-ний өдрийн гүйцэтгэгчийн саналыг захиалагч хүлээн зөвшөөрсөн.

### ЭНЭХҮҮ ГЭРЭЭГЭЭР ДАРААХЬ ЗҮЙЛСИЙГ ГЭРЧИЛНЭ:

1. Гүйцэтгэгч энэхүү гэрээ (Хавсралт 1)-ний салшгүй хэсэг болох гүйцэтгэгчийн санал дахь ажлын хүснэгт (эсхүл ажлын тоо хэмжээ)-д дурдсан бүх ажлыг гэрээний дараах нөхцөл шаардлагын дагуу мэргэжлийн түвшинд чадвартайгаар хийж гүйцэтгэх үүрэг хүлээнэ:
  - a) Гэрээг хэрэгжүүлэх үед болон чанарын баталгаат хугацааны туршид гарах бүх гэмтэл согогийг, хариуцсан инженерээс мэдэгдэл авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор засч арилгах;
  - b) Гэрээний гүйцэтгэл хангалтгүй тохиолдолд захиалагч бичгээр мэдэгдсэнээс хойш 21 өдрийн дараа гэрээг цуцлах эрхтэй. Хэрэв гэрээ нь дайн, эсвэл захиалагч эсхүл гүйцэтгэгчийн хяналтаас үл хамаарах аливаа явдлын болж хэрэгжээгүй тохиолдолд хариуцсан инженер нь гэрээ хэрэгжээгүй болохыг нотлох ёстой. Ийм тохиолдолд, захиалагч ба гүйцэтгэгч нар нөгөө талдаа санхүүгийн ямар нэгэн үр дагавар учруулахгүйгээр 21 өдрийн мэдэгдэл хүргэх замаар гэрээг цуцлах эрхтэй. Гэрээг цуцалсаны дараа төлбөр хийхдээ, хийж дуусгасан ажил, нийлүүлж хүргэсэн барааны үнэ өртөг, болон урьдчилгаа төлбөр зэргийг харгалзана;
  - c) Хэрэв гүйцэтгэгчийн буруутай үйлдлээс болж гэрээг цуцласан тохиолдолд, ажлын талбай дээр байгаа бүх материал, барилгын тоног төхөөрөмж, дуусаагүй болон дууссан ажил нь захиалагчийн өмч хөрөнгө болно;
  - d) Гүйцэтгэгч бүх тохиолдолд хариуцсан инженерийн удирдамжийг баримтлан ажиллана;
  - e) Гүйцэтгэгч хариуцсан инженерт гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 7 өдрийн дотор ажлын хөтөлбөрийг гаргаж өгөх ба үүнд ажил хийж дуусгах ерөнхий арга зүй, хуваарийг тусгана;
  - f) Гэрээг дуусгах хугацаа: Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш **2 сар**;
  - g) Ажлын аль нэг хэсгийг захиалагчийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр туслан гүйцэтгэгчээр хийлгэхийг хориглоно;
  - h) Хариуцсан инженерийн захиалгын дагуу, харилцан тохиролцсон нэгж үнийг үндэслэн шинээр гүйцэтгэсэн ажлыг төлнө. Хэрэв гүйцэтгэгч ба хариуцсан

инженер харилцан тохиролцож чадахгүй тохиолдолд, хариуцсан инженерийн тогтоосон нэгж үнийг гүйцэтгэгч дагаж мөрднө;

- i) Гэрээний дагаж мөрдөх хууль нь **Монгол** улсын хууль тогтоомж байна;
  - j) Гүйцэтгэгч ажлын талбайд явуулах бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна;
  - k) Ажлыг гүйцэтгэх явцад, хариуцах байгууллага болох Бичигт хилийн боомтын Гаалийн газар талбай дээр ажлын гүйцэтгэлийг шалгах бөгөөд батлагдсан тодорхойлолтын дагуу, шаардсан чанарын хэмжээнд хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж нотлоно. Бичигт хилийн боомтын Гаалийн газар нь шаардсан тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэгүй ажлаас татгалзах бөгөөд гүйцэтгэгч "а" дэд зүйлд заасны дагуу бүх гэмтэл согогийг засч арилгах арга хэмжээг яаралтай авна;
  - l) Урьдчилан тааварлах боломжгүй нөхцөл байдал, тухайлбал дайн, түүнчлэн газар хөдлөлт, үер, гол түймэр гэх мэт байгалийн гамшиг тохиолдсон бол аль ч тал нь нөгөө талдаа 21 өдрийн мэдэгдэл гаргах замаар гэрээг цуцлаж болно. Ийм тохиолдолд төлбөрийг гэрээг цуцалсан өдрөөр тасалбар болгон гүйцэтгэнэ;
  - m) Гүйцэтгэгч **Монгол** улсын хууль тогтоомжийн дагуу бүх татвар, хураамж, ногдолыг хариуцна; ба
  - n) Захиалагч ба гүйцэтгэгч нь тэдгээрийн хооронд гэрээтэй холбогдон гарч болох аливаа үл тохиролцол эсвэл маргааныг зөвшилцэн шийдвэрлэнэ. Маргааныг шийдвэрлэж чадахгүй тохиолдолд, аль нэг тал нь гэрээнд мөрдөх хууль тогтоомжийн дагуу уг маргааныг **Монголын Үндэсний Худалдаа, Аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр-д** шилжүүлнэ.
2. Дээрх зүйлсийг харгалzan, захиалагч нь гүйцэтгэгчид дараах арга нөхцөлийн дагуу \_\_\_\_\_ (үг ба тоогоор илэрхийлэх) бүхий гэрээний үнийг төлөх үүрэгтэй:
- (i) Гүйцэтгэгчийн нэхэмжлэх, Захиалагч болон Гүйцэтгэгчийн гарын үсэг зурж батапгаажуулсан ажип хүпээн авсан актад үндэслэн, гүйцэтгэсэн ажлыг Захиалагч хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор 100 хувь.
3. Барилгын тухай хуулийн 14.3 дахь зүйлийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил, 14.6 дахь зүйлийн дагуу хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

Талууд энэхүү гэрээг дээр дурдсан өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр үүгээр байгуулав.

Боомтын сэргэлтийн үндэсний хороог  
төлөөлж:

О.НАРАНДЭЛГЭР, БООМТЫН  
СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Эрх бүхий төлөөлөгчийн нэр

## ЗӨВШӨӨРЛИЙН ЗАХИДАЛ

Огноо: \_\_\_\_\_

Хэнд: \_\_\_\_\_ [Гүйцэтгэгчийн нэр ба хаяг]

Эрхэм хүндэт \_\_\_\_\_ танаа,

Саналын хүсэлтийн дагуу запруулж өөрчилсөн \_\_\_\_\_ [гэрээний дугаар ба нэр] гэрээт ажлыг \_\_\_\_\_ [гэрээний үнийн дүнг үсэг ба тоогоор оруулах] үнийн дунд багтаан хийж гүйцэтгэхээр ирүүлсэн таны саналыг бид хүлээн зөвшөөрч байгааг танд үүгээр мэдэгдэж байна.

Түүнээс гадна та хавсралтанд байгаа гэрээний маягтанд гарын үсэг зурж, ажлыг өдрөөс хэтрүүлэхгүйгээр эхлүүлэхээс гадна гэрээнд заасан барилгын ажлын хугацаанд багтаан хийж дуусгахаа баталгаажуулна уу.

Захиалагчийг төлөөлж:

Эрх бүхий гарын үсэг: \_\_\_\_\_

Гарын үсэг зурах этгээдийн нэр:

Албан тушаал: \_\_\_\_\_